



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/169

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын Засгийн газрын Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн санхүүжилт, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Булган аймгийн Булган сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн засварын төсөл”-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Хурмастын хүлэг” ХХК-тай 833,400,000 (найман зуун гучин гурван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хөдөө аж ахуйн Их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийн захирал (Н.Пүрэвсайхан)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Хурмастын хүлэг” ХХК-ийн захирал (Г.Ганзориг)-д даалгасугай.

5. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 13,360,584 (арван гурван сая гурван зуун жаран мянга таван зуун наян дөрөв) төгрөгөөр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 05-ны/ний өдрийн А.А.69 дүгээр
захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	15,476,326	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	15,476,326	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	7,738,163	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19,500,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	1,392,869	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Д.Батцогт
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 90 хоног	Ү.Бямбасүрэн
10	Баталгаат хугацаа	Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанаас хойш 3 жил байна. /Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт/	Ү.Бямбасүрэн Н.Пүрэвсайхан